

"ТУСАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНД,  
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ" II ШАТ

А үсэг бүтээцгээ



**ТЭГШ ХАМРУУЛАН  
СУРГАДАГ СУРГУУЛЬ**

Сайн жишээний ЭМХЭТГЭЛ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



“ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДАГАТАЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНД,  
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ” II ШАТ



# ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАДАГ СУРГУУЛЬ

Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулж буй  
сургуулиудын туршлагын эмхэтгэл

2024 он

**ННА-74**  
**ДДА-370**  
**Т-865**

**Боловсруулсан:**

“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн баг

**Хянасан:**

Боловсролын ерөнхий газрын Тэгш хамруулах боловсролын хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Уянга

Боловсролын ерөнхий газрын Тэгш хамруулах боловсролын хэлтсийн мэргэжилтэн Д.Даваасүрэн

**Зөвлөсөн:**

Боловсролын ерөнхий газрын Суралцагчийн хөгжлийн газрын дарга Ж.Болормаа

Боловсролын ерөнхий газрын Тэгш хамруулах боловсролын хэлтсийн дарга Э.Чулуунхишигт

*Энэхүү ном нь Монгол улсын “Зохиогчийн эрхийн тухай” хуулиар баталгаажсан тул эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэх, цахим болон бусад хэлбэрээр хувилан олшруулах, түгээн тараахыг хориглоно.*

*Зөвлөмжийг ЖАЙКА-тай хамтран боловсруулсан ба зохиогчид болон кейс жишээ нь тухайн багшийн үзэл бодлыг илэрхийлсэн бөгөөд ЖАЙКА-гийн албан ёсны үзэл бодлыг тусгаагүй болно. Зургийг тухайн хүн эсвэл асран хамгаалагчийн зөвшөөрөлтэйгээр ашиглав.*

ISBN: 978-9919-9055-9-0

## ГАРЧИГ

Өмнөх үг .....	4
1. Сургуулийн орчин бүрдүүлэх .....	5
1.1. Ханын бариул хийх .....	6
1.2. Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим байгуулах .....	7
1.3. Хэрэглэгдэхүүн, сургалтын материал худалдан авах .....	8
2. Анги зохион байгуулалт .....	9
2.1. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах .....	12
2.2. Анги зохион байгуулалт, суудал хуваарилах .....	13
2.3. Ганцаарчилсан тохирох хэрэглэгдэхүүн боловсруулах .....	14
2.4. Ганцаарчилсан сургалт зохион байгуулах .....	15
2.5. Хичээлийн цаг хуваарилалтын тохируулга .....	16
2.6. Математикийн хичээлийн арга зүй-туслах хэрэглэгдэхүүн ашиглах .....	17
2.7. Биеийн тамирын хичээлд найз нөхөд, үе тэнгийнхний харилцаа ...	18
2.8. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа .....	19
3. Дэмжлэг, хамтын оролцоо .....	20
3.1. Сургуулийн дэмжлэгийн багийн үйл ажиллагаа .....	20
3.2. Багш нарын хамтын ажиллагаа .....	21
3.3. Эцэг эх асран хамгаалагч нартай хамтран ажиллах .....	22
3.4. Хүүхэд хоорондын харилцаа .....	24

## ӨМНӨХ ҮГ

Монгол улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, ЖАЙКА Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хамтран “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн II шатыг 2020-2024 онд хэрэгжүүллээ. Тус төсөл нь үндэсний хэмжээнд ерөнхий боловсролын сургуулиудад тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхээр зорин ажилласан.

Сайн туршлагыг нэгтгэн Боловсрол шинжлэх ухааны яам, Боловсролын ерөнхий газрын арга зүйч, мэргэжилтнүүд, ерөнхий боловсролын сургуулийн холбогдох албан тушаалтнуудаас санал зөвлөгөө, мэдээлэл авч Тэгш хамруулан сургадаг сургуулийн “Сайн жишээний эмхэтгэл”-ийг боловсруулан олон нийтийн хүртээл болгож байна. Энэхүү эмхэтгэл нь тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэгч, дэмжигч сургууль болоход тус болох, санаа авах олон сайн жишээнүүдийг агуулсан тул та бүхэн танилцан, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэхийг хүсье.

Мөн эмхэтгэл боловсруулахад хамтран ажилласан бүх хүмүүстээ чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Уг эмхэтгэлээр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй, хөгжлийн хоцрогдолтой эсэхээс үл хамааран бүх хүүхэд хамтдаа сурч хөгждөг сургууль, хамт олон болох зорилгодоо хүрэх их үйлсэд нь амжилт хүсье.



## 1. СУРГУУЛИЙН ОРЧИН БҮРДҮҮЛЭХ

Тэгш хамруулан сургах боловсролын бодлогыг хэрэгжүүлэхэд чухал шийдэх асуудлуудын нэг бол сургууль, ангийн орчин сайжруулах юм.

Бүх хүүхэд суралцах тохируулгат орчныг бүрдүүлснээр сургууль, боловсролын байгууллагад аюулгүй орчинд суралцах боломж нэмэгдэнэ. Хөгжлийн бэрхшээлтэй төдийгүй нийт хүүхдүүдийн хувьд ээлтэй сургууль байх болно.

### АГУУЛГА, АРГА ЗҮЙ

Налуу зам тавих, босгоны налуу тааруулах, ханын бариул суурилуулах, анги танхим, хүүхдийн хөгжлийг дэмжих танхимыг тохижуулах, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, үзэг бал, дэвтэр гэх мэт бичгийн хэрэгсэлд тохируулга хийх, шаардлагатай хэрэглэгдэхүүнийг худалдан авч хэрэглэдэг болсноор хүүхэд бүр сургуульдаа цагийг баяр жаргалтай өнгөрүүлэх боломжтой. Сургууль, ангийн орчныг сайжруулахын тулд чадах бүхнээ хийх хэрэгтэй. Ингэснээр бид зөвхөн ялгаатай хэрэгцээтэй төдийгүй ямар ч хүүхдийг бүгдийг хүлээн авах боломжтой болно. Орчин сайжруулах, суралцахуйн түгээмэл загвар, дэлхий нийтийн чиг хандлагын талаар дараах видеог үзэж танилцан мэдээлэл авна уу.



[https://www.medle.mn/additional/start2\\_2024\\_1.mp4](https://www.medle.mn/additional/start2_2024_1.mp4)

### ОРЧИН БҮРДҮҮЛЭХ

Хэд хэдэн сургуулийн жишээг танилцуулъя.

- Сургуулийн хаалганд налуу зам, ангид налуу босго тавьсан
- Хаягжилтыг шинэчлэн нэгдсэн зураг, таних тэмдэг ашиглан ямар анги танхим болох нь тодорхой, ойлгомжтой байхаар хийсэн
- Ангийн мэдээллийн самбарт байршуулах мэдээллийн өнгө загвар, агуулгыг зөв сонгосноор, хараагаар хүртэх цочролыг багасгасан
- Ариун цэврийн өрөөнд ханын бариул суурилуулсан
- Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим байгуулсан
- Таблет гэх мэт технологийн шийдэл, давуу талыг ашиглан ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд суралцахад хялбар сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн бэлдсэн



## Сургуулийн орчин бүрдүүлэх

### 1.1. Ханын бариул хийх (Жишээ 1)

#### Үндсэн мэдээлэл

Аймгийн нэр: Өмнөговь аймаг  
Сургуулийн нэр: Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль  
Багшийн нэр: Ө.Цэцэг-Өлзий

#### Дэмжлэгийн өмнөх асуудал

Сургуулийн ариун цэврийн өрөө, шат ханан талдаа бариулгүй учир суралцагч бие засах, шатаар өгсөж, уруудахад хүндрэлтэй байдаг

#### Багшийн дэмжлэгийн арга зүй

Сургуулийн удирдлага, дэмжлэгийн багтай хамтран шат болон ариун цэврийн өрөөний хананд бариул суурилуулсан.

#### Гарсан үр дүн

Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд шатаар өөрөө өгсөж, уруудаж чаддаг болсон. Сургуулийн орчинд чөлөөтэй явах боломж нэмэгдсэн. Мөн Харааны бэрхшээлтэй хүүхдийн орон зайн баримжааны чадвар сайжирсан.

Ариун цэврийн өрөөнд бариул хийснээр тэргэнцэртэй хүүхэд бусдын тусламжгүйгээр бие засах боломжтой болсон.



Шатаар өгсөхөд амар болсон.



Ариун цэврийн өрөөний бариул

## 1.2. Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим байгуулах (Жишээ 2)

### Үндсэн мэдээлэл

Аймгийн нэр: Өвөрхангай аймаг  
 Сургуулийн нэр: Хархорин сумын 2 дугаар сургууль  
 Багшийн нэр: Ё.Батцэцэг, С.Пүрэвдулам

### Дэмжлэгийн өмнөх асуудал

Уналт, таталттай хүүхэд, хөнгөн, дунд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуулийн ээлтэй орчин бүрдээгүйн улмаас сургууль завсардах асуудал тулгамддаг.

### Багшийн дэмжлэгийн арга зүй

Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд зориулсан хүүхдийн хөгжлийг дэмжих танхимыг сургууль болон сумын хандивлагчдын дэмжлэг, хамтын ажиллагаагаар байгуулан тохижуулсан. Тус танхимд суралцагчтайгаа ганцаарчлан ажиллахад тохиромжтой сургалтын хэвлэмэл болон биет хэрэглэгдэхүүн болон хүүхдийн онцлог хэрэгцээнээс хамаарч амарч, тав тухтай хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлэхээр буйдан, хивс гэх мэт зүйлсийг нэмж тохижуулсан. Сургууль завсардсан хүүхдүүдийн 5 нь сургуульд хамрагдсан. Сургуулийн орчин сайжирснаар хүүхэд суралцахад хялбар болж, сургуульдаа дуртай болсон.



Худалдан авсан хэрэглэгдэхүүнүүд



Хүүхдийн хөгжлийг дэмжих танхимд хичээллэх, амрах орчин бүрдүүлсэн байдал

### 1.3. Хэрэглэгдэхүүн, сургалтын материал худалдан авах (Жишээ 3)

#### Үндсэн мэдээлэл

Аймгийн нэр: Дорнод аймаг  
Сургуулийн нэр: Сэргэлэн сумын сургууль  
Багшийн нэр: захирал П.Эрдэнэцэцэг

#### Дэмжлэгийн өмнөх асуудал

- ① Биеийн тамирын хичээлийн явцад бие эрхтний бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх хэрэглэгдэхүүн огт байгаагүй учир тухайн хүүхдийг хичээлд оролцуулах боломжгүй байсан.
- ② Математикийн хялбар тоо бодож чадахгүй хүүхдэд тохирох хэрэглэгдэхүүн байхгүй, хичээлд оролцуулах боломжгүй байсан.

#### Багшийн дэмжлэгийн арга зүй

- ① -ийн хүүхдийн хувьд ангийн хүүхдүүдтэй хамт биеийн тамирын хичээлд оролцон зориулалтын гатаар хананд авирч, биедээ тохирсон дасгал хөдөлгөөнийг өөрийн чадах хурдаар хийх боломжтой болсон.
- ② -ын хүүхэд бол тооны машины хэрэглээг сурснаар энгийн хялбар тоог өөрөө боддог болсон.



Биеийн тамирын хичээл



Математик


## 2. АНГИ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ангийн орчинд нь дэмжлэг үзүүлэх нь хүүхэд нэг бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн тохирох хэрэглэгдэхүүн боловсруулах болон түгээмэл загвар дээр суурилсан багшийн хүчин чармайлтын үр дүнд бий болдог. 2006 онд батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц”-д тохирох орчны тухай тусгагдсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусад хүүхдүүдийн адил эрхээ эдлэх боломжийг олгох зорилготой юм.

Түгээмэл загвар гэдэг бол хөгжлийн бэрхшээлтэй эсэх, нас, хүйс, үндэс угсаа, арьсны өнгө, хэл соёлоос үл хамааран бүх хүмүүст хялбар, ээлтэй, тав тухтай ашиглах боломжтой барилга байгууламж, бүтээгдэхүүн үйлчилгээ болон орчны төлөвлөлтийг хэлнэ. Энэ нь анх барилга, архитекторын салбарт ашиглагдаж байсан ойлголт боловч сүүлийн жилүүдэд суралцахуйн түгээмэл загвар гэдэг нэр томъёо, ойлголт руу шилжиж, дэлхий нийтэд түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа болж байна.

Дараах бүдүүвч зурагт ердийн ангид үзүүлэх дэмжлэгийн шатлалыг зургаар харуулав. Нэгдүгээр шат бол зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төдийгүй ангийн бүх хүүхдэд ойлгомжтой хялбар, тохируулга хийсэн анги танхимыг бий болгох. Хоёрдугаар шатанд бага зэрэг дэмжлэг анхаарал шаарддаг хүүхдүүдэд чиглэсэн бөгөөд жижиг бүлгээр ажиллах, харин харин гуравдугаар шат нь ганцаарчлан ажиллах, илүү их дэмжлэг шаарддаг хүүхдүүдэд зориулагдсан юм.

Multi-Tiered System of Supports (MTSS)



Эх сурвалж: Шигэки Фүжи, Юмико Сайто (2010) Ердийн сургуулийн ердийн ангид өгөх зөвлөгөө - Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй болон нийт хүүхдүүдэд зориулсан боловсролын үр нөлөө. 2007-2021 оны Шинжлэх ухааны судалгааны буцалтгүй тусламж (суурь судалгаа Б)-ийн судалгааны үр дүнгийн тайлан.

## Анги зохион байгуулалт

1. Нэгдүгээр шатны үйл ажиллагаа, дэмжлэгийг илүү их хийснээр “Бүх хүүхдэд ээлтэй, ойлгомжтой ангийн орчин” бүрдэж, “Ойлгомжтой хичээл” зохион байгуулж чадна. Тохирох орчин, хэрэглэгдэхүүний хэрэгцээ ч багасах боломжтой.

### АРГА ЗҮЙН ТОХИРУУЛГА

Суралцагчдын хэрэгцээнд нийцсэн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, ямар нэгэн бэрхшээлийг даван туулахад нь дэмжлэг үзүүлэхийн тулд тодорхой нэг хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн өвөрмөц онцлог нөхцөл байдал нь тэдэнд хэрхэн нөлөөлдөг талаар мэдэх хэрэгтэй. Яг адил бэрхшээлтэй суралцагчид байлаа ч мэдлэг туршлага, хэрэгцээ нь өөр өөр учраас тэдний суралцахуйг дэмжих арга, стратеги нь өөр хоорондоо харилцан адилгүй ялгаатай байна

Тодорхой жишээ дурдвал:

- Сул хараатай хүүхдэд томруулагч шил ашиглан хичээллэх, шалгалтын үеэр хэрэглүүлэх
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд дохионы хэлмэрч болон тэмдэглэл хөтлөгч бэлдэх
- Хэл ярианы бэрхшээлтэй хүүхэд ярих үед өөртөө итгэлтэй байх хэл заслын дэмжлэг үзүүлэх
- Унших чадвар сул хүүхдэд DAISY<sup>1</sup> форматтай хэрэглэгдэхүүн ашиглуулах
- Бичих чадвар сул хүүхдэд өргөн шугамтай дэвтэр бэлдэх
- Бие эрхтний бэрхшээлтэй хүүхдийн биеийн тамирын хичээлийн агуулгыг өөрчлөх
- Бэрхшээлийн онцлог, хүүхдийн хөгжлийн чадвар даалгавар гүйцэтгэлийн хугацаанаас хамаарч шалгалтын цагийг тохируулах

### СУРАЛЦАХУЙН ТҮГЭЭМЭЛ ЗАГВАР

Суралцахуйн түгээмэл загвар гэдэг нь ангид байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төдийгүй ялгаатай хэрэгцээтэй, ялгаатай суралцахуйн хэв шинжтэй хүүхдэд зориулж тохируулга хийх, багш хичээлээ бэлдэж явуулах, мөн ангид тохируулга хийж, орчныг бүрдүүлэх тухай ойлголт юм. Америкийн боловсролын судалгаа, хөгжлийн байгууллага болох CAST<sup>2</sup>-ийн үзэж байгаагаар суралцахуйн түгээмэл загварын гурван зарчим байна.

1 Digital Accessible Information System гэх үгсийн товчлол, харааны бэрхшээлтэй болон ердийн хэвлэмэл ном, сэтгүүл уншихад хүндрэлтэй хүмүүст зориулсан технологийн шийдэл, цахим брайл төхөөрөмж, ярьдаг номын сангийн олон улсын нэршил. Хэрэглэгчид нь аудио сонсонгоо, тодоор будсан текстийг унших, мөн нэг дэлгэц дээрх зургийг харах боломжтой.

2 <https://udlguidelines.cast.org/UDL Guidelines>: Энэ хаягаар татаж авч ашиглах боломжтой.

• **Төлөөлөх:**

Хүүхэд нэг бүрд мэдээлэл өгөх заах агуулгаа дамжуулахын тулд “Ялгаатай” арга зүй бэлтгэнэ. Янз бүрийн аргыг урьдчилан бэлтгэсэн тодорхой жишээнүүдийг доор танилцуулж байна.

- Өдөр тутмын үйл ажиллагаа, ангийн үйл ажиллагаа, дарааллыг ойлгомжтой танилцуулах
- Хүүхдэд ойлгомжтой байх хэрэглэгдэхүүн олон төрлөөр бэлдэх
- Хүүхэд үйл ажиллагааны явцдаа сурах боломжтой сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлдэх.
- Мэдээлэл эмх цэгцтэй, ойлгомжтой самбар төлөвлөлт хийх
- Проектор, ухаалаг ТВ зэргийг ашиглан, хараад ойлгомжтой байх хичээлийг явуулах



• **Үйлдэл хийх, илэрхийлэх:**

Хүүхэд нэг бүр өөрийн бодол санаа, ойлгосон зүйлсээ илэрхийлэх, гаргахын тулд “Ялгаатай” аргуудыг бэлдэх

- Хичээлийн явцад дүрийн тоглолт, мэтгэлцээн, хэлэлцүүлэг зэрэг аргуудаас оруулах
- Хүүхдэд судалж үзэж, бодож байгаа зүйлээ танилцуулах боломжийг олгох.
- Шалгалтын үеэр янз бүрийн хариултын хэлбэрийг (олон сонголтоос сонгох, холбох, богино хариулт өгөх, хоосон зайг бөглөх гэх мэт) ашиглах
- Даалгавраа сайтар тунгаан бодож хийдэг хүүхдүүдэд подкаст үзэх, нэмэлт цаг өгөх зэргээр хичээлийн бус цагаар суралцах боломжийг олгох
- Хүүхэд өөртөө зорилго тавьж, түүндээ хүрэхэд нь туслах үйл ажиллагааг тусгах

• **Оролцох:**

Хүүхэд нэг бүр өөрийн хүсэл сонирхлоороо хичээл сургалтын үйл ажиллагаанд оролцож байх “Ялгаатай” арга зүй бэлдсэн байх

- Хичээлийн хуваарь, ангийн дэгийг ойлгомжтой газар байрлуулах
- Хосоор ажиллах, багаар ажиллах үед хүүхдүүд бие биеэсээ суралцах, туслах боломжийг бүрдүүлэх
- Хүүхэд нэг бүрийн чадварыг мэдэж тохирох даалгаврыг өгөх тул хэд хэдэн түвшний ялгаатай даалгавруудыг бэлдэх

## Анги зохион байгуулалт

### 2.1. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах (Жишээ 4)

#### Үндсэн мэдээлэл

Аймгийн нэр: Булган аймаг  
Сургуулийн нэр: Бугат сумын сургууль  
Багшийн нэр: Б.Отгонжаргал

#### Дэмжлэгийн өмнөх асуудал

Хэл ярианы бэрхшээлтэй хүүхдэд багш тохирох дэмжлэг үзүүлж чадахгүй байсан. Тухайн хүүхэд унших, бичих, тооцоолон бодох чадвар сул, хоцрогдолтой. Үсэг таних, дуудаж уншихдаа хүндрэлтэй.

#### Багшийн дэмжлэгийн арга зүй

Сургуулийн нийгмийн ажилтантай хамтарч, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулсан. Хэл заслын хичээлийн арга зүйд үндэслэсэн дуудлагын дасгал хийж, дараа нь үсэг, үеэр тасалж унших дасгал, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний дагуу үе шаттай багш авиан сонсгол хөгжүүлэх арга зүйг хэрэгжүүлсэн.

#### Гарсан үр дүн

35 үсгээ цээжилсэн, багшаас богино үетэй үг хэлэхэд сонсоод, цээжээр бичиж чаддаг болсон.



Үсэг зөв дуудах дасгал

## 2.2. Анги зохион байгуулалт, суудал хуваарилах (Жишээ 5)



### Үндсэн мэдээлэл

Дүүргийн нэр: Багануур дүүрэг  
 Сургуулийн нэр: Гүн Галуутай цогцолбор сургууль  
 Багшийн нэр: Ц.Отгонтөгс



### Дэмжлэгийн өмнөх асуудал

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээг ойлгох, түүнд тохирсон сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, ажиллах арга зүйн талаар багш ойлголтгүй байсан.



### Багшийн дэмжлэгийн арга зүй

Сул сонсголтой хүүхэд тул түүнийг хөдөлгөөн багатай, тайван дөлгөөн хүүхдийн хажууд суулгасан. Мөн хичээлийн хуваарь, өдрийн дэглэм, хичээлийн хэрэгслийг хүүхдэд сайн харагдах байдлаар байрлуулсан.



### Гарсан үр дүн

Сонгосон хүүхдийн хажууд сууж буй хүүхдэд ойлгохгүй байгаа зүйлийг нь тайлбарлаж тусалж, хичээлдээ саадгүй оролцох боломжийг олгосон. Мөн хичээлд саадгүй оролцдог болсны үр дүнд зорилтот хүүхдүүдийн сурлагын чанар, гүйцэтгэл сайжирсан.



Хичээлийн хэрэгслийн харагдах байдал



Ангийн булан, зурагт үзүүлэн

## 2.3. Ганцаарчилсан тохирох хэрэглэгдэхүүн боловсруулах (Жишээ 6)

### Үндсэн мэдээлэл

Аймгийн нэр: Орхон аймаг  
Сургуулийн нэр: 16 дугаар дунд сургууль  
Багшийн нэр: Ч.Хандсүрэн

### Дэмжлэгийн өмнөх асуудал

Ангийн сурагчид унших болон уншиж ойлгох чадварын хувьд ялгаатай, ялгаатай байдалд нь тохирсон хэрэглэгдэхүүн байхгүй.

### Багшийн дэмжлэгийн арга зүй


Сурагчдын уншиж ойлгох чадварыг тогтоон, 4 түвшинд хуваасан. Бэрхшээлтэй эсэхээс үл хамааран түвшин тус бүрд тохирсон унших эх, даалгавруудыг бэлтгэсэн. Эцэг эх асран хамгаалагчидтай хамтран гэртээ ашиглах боломжтой унших чадварыг тэмдэглэх хуудас боловсруулсан.

### Гарсан үр дүн

Хүүхдүүдийн унших чадвар дээшилж, хичээлийн идэвх, оролцоо сайжирсан.



Түвшин тус бүрээр хэрэглэгдэхүүн боловсруулсан.



Унших чадварыг тэмдэглэх хуудас

## 2.4. Ганцаарчилсан сургалт зохион байгуулах (Жишээ 7)



### Үндсэн мэдээлэл

Аймгийн нэр: Өвөрхангай аймаг  
 Сургуулийн нэр: Хархорин сумын 2 дугаар сургууль  
 Багшийн нэр: С.Пүрэвдулам



### Дэмжлэгийн өмнөх асуудал

Дан ганц сурах бичиг хүүхдийн сонирхлыг татах боломжгүй, хүүхдийн ойлголт, чадварыг хөгжүүлэхэд хэцүү байсан. Зөвхөн нэг төрлийн сургалтын хэрэглэгдэхүүн нь хүүхдийн хэрэгцээг хангахгүй байсан.



### Багшийн дэмжлэгийн арга зүй

Хүүхдийн онцлог, чадвар, сонирхолд тулгуурлан өөрийн гараар сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэсэн. Жишээлбэл, тэдэнд үг уншиж, хуулах даалгавар өгдөг боловч хурдан мартдаг байв. Тиймээс багш нар дахин ашиглах боломжтой үг болон зурган картуудыг ламинатор ашиглан бэлдсэн.



### Гарсан үр дүн

Зурган карт, үгэн картыг хослуулан ашиглаж ганцаарчлан ажилласнаар хүүхэд үгсийг ойлгоход их дэмжлэг болсон. Түүнчлэн сургалтын хэрэглэгдэхүүнийг тухайн хүүхдийн ганцаарчилсан хичээлд зориулсан ч бусад хүүхдүүдтэй хамт хэрэглэгдэхүүнийг ашиглах цаг, боломж бүрдүүлж байснаар бусадтай хамтран ажиллах чадвар нь нэмэгдсэн.



Зурган болон үгэн карт



Хэрэглэгдэхүүн хэрэглэж байгаа байдал

## 2.5. Хичээлийн цаг хуваарилалтын тохируулга (Жишээ 8)

### Үндсэн мэдээлэл

Аймгийн нэр: Дорноговь аймаг  
 Сургуулийн нэр: Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль  
 Багшийн нэр: Ц.Мөнхсаруул

### Дэмжлэгийн өмнөх асуудал

Эцэг, эхийн хүсэлтээр үеийн хүүхдүүдтэй хамтдаа хичээллэж байсан ч ангийн хэт их чимээ шуугианаас шалтгаалан хичээлд оролцож чадахгүй байсан.

### Багшийн дэмжлэгийн арга зүй

Танхимаар ганцаарчлан хичээллэх үед 40 минутын хичээл нь түүний анхаарал төвлөрөх хугацаанаас хэт урт байсан тул хичээлийн цагийг 25 минут болгож, дунд нь 5 минутын завсарлага авч дахин 25 минут хичээллэхээр төлөвлөсөн. Мөн ажиглалтад үндэслэн цагийн хуваарийг шинэчлэн өдөрт орох хичээлийн тоог 4 цаг хүртэл байхаар өөрчилсөн. Зарим хичээлийг ангийн хүүхдүүдтэй хамт хичээллэх, оролцоог дэмжихийн тулд танхимийн хичээлд бага багаар дасгах, мөн эцэг эх нь харгалзан дэмжиж ажиллахаар төлөвлөж байна.

Хичээлийн цаг багассан ч тухайн хүүхэд бие физиологийн хувьд ядардаг хэвээр байсан тул амраах зөөлөн дэвсгэр, шалан дээр суугаа, хэвтээгээрээ ч хичээл хийх боломжтой орчин бүрдүүлсэн.

### Гарсан үр дүн

Анхаарал нь төвлөрч, хичээлийн 40 мин дуустал оролцож чаддаг болсон.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
14 <sup>00</sup> -14 <sup>25</sup>	Математик	Монгол хэл	Математик	Математик	Монгол хэл
14 <sup>30</sup> -14 <sup>45</sup>	Хөдөлгөөн засал	Хөдөлгөөн засал	Дуу хөгжим	Хөдөлгөөн засал	Дуу хөгжим
15 <sup>00</sup> -15 <sup>15</sup>	Монгол хэл	Математик	Монгол хэл	Дүрслэх урлаг	Хүн ба орчин
15 <sup>20</sup> -15 <sup>35</sup>	Дүрслэх урлаг	Монгол ёс хумүүжил	Хүн ба орчин	Багш мэдлийн цаг	Монгол ёс хумүүжил

Хичээлийн хуваарь



Тохируулга хийсэн ангийн орчин

## 2.6. Математикийн хичээлийн арга зүй (туслах хэрэглэгдэхүүн ашиглах) (Жишээ 9)



### Үндсэн мэдээлэл

Аймгийн нэр: Өвөрхангай аймаг  
Сургуулийн нэр: Хархорин сумын 2 дугаар сургууль  
Багшийн нэр: С.Пүрэвдулам



### Дэмжлэгийн өмнөх асуудал

Тоо бодох чадвар сул, хүүхэд хичээлд оролцохгүй, ойлгохгүй байсан.




### Багшийн дэмжлэгийн арга зүй

Тооцоолох үйлдлийг зөв гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхэд туслах зорилгоор бид дахин ашиглаж болох нэмэлт тоо бичих нүднүүд бэлтгэж өгсөн. Өгүүлбэртэй бодлого хэцүү байдаг тул аль болох хөдөлгөөний бодлого, дэлгүүрээс худалдан авалт хийх гэх мэт хүснэгт, бодит хэрэглэгдэхүүн ашигласан хичээл төлөвлөн ажилласан.



### Гарсан үр дүн

Хүүхдүүд шугамдаж бэлдсэн нүднүүд болон хүснэгт ашиглан дөрвөн аргын үйлдэл хийх боломжтой болсон. Түүнээс гадна хүснэгт, бодит юмс, хэрэглэгдэхүүн ашиглан хичээлд хэрэгжүүлснээр зөвхөн ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдэд төдийгүй математикийн хичээлдээ сул, ангийн нийт хүүхэд ойлгоход тусалсан.



Нэмэлт тоо бичих нүд



Бодит хэрэглэгдэхүүн ашигласан хичээл

## Анги зохион байгуулалт

### 2.7. Биеийн тамирын хичээлд найз нөхөд, үе тэнгийнхний харилцаа (Жишээ 10)

#### Үндсэн мэдээлэл

Аймгийн нэр: Сэлэнгэ аймаг  
Сургуулийн нэр: Сүхбаатар сумын 1 дүгээр сургууль  
Багшийн нэр: А.Хулан

#### Дэмжлэгийн өмнөх асуудал

Нийгэмшихүйн чадвар сул, бусад хүүхдүүдтэй хэрхэн харьцахаа мэдэхгүй, хичээлийн явцад ч бусадтай харилцдаггүй байсан.

#### Багшийн дэмжлэгийн арга зүй

Биеийн тамирын хичээлд ангиараа үсэрч, харайж, гүйж байх зуураа бага багаар харилцаанд орж, дасгал хөдөлгөөн, буухиа тэмцээний үеэр хамтарч үйл ажиллагаанд оролцохыг суралцсан. Мөн заал руу явах үед шаардлагатай бол найзууд нь тусалдаг болсон.

#### Гарсан үр дүн

Ангийн хүүхдүүдтэй биеийн тамирын хичээлд хамт оролцдог болсон.



Биеийн тамирын хичээл



Ангиас заал руу очиж байгаа байдал

## 2.8. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа (Жишээ 11)

### Үндсэн мэдээлэл

Аймгийн нэр: Орхон аймаг  
 Сургуулийн нэр: Баян-Өндөр сумын 2 дугаар сургууль  
 Багшийн нэр: Э.Энхчимэг

### Дэмжлэгийн өмнөх асуудал

Хичээлийн бус цагаар хүүхдийг хөгжүүлэх ямар нэг үйл ажиллагаа хийдэггүй байсан.

### Багшийн дэмжлэгийн арга зүй

Хүүхдээс, эцэг эхээс асууж лавлан, тус тусын онцлогт тохирсон гар урлал, цаас нугалах, веб хуудас хийх үед оролцох зэргээр дэмжлэг үзүүлсэн.

### Гарсан үр дүн

Сургалтын хөтөлбөрт тусгагдсан хүүхдийн хөгжлийн түвшнээс илүү сайжирсан. Жишээлбэл: Веб хуудас хийх зэрэг ирээдүйн ажил, мэргэжилтэй холбоотой хэрэг болох чадвар нэмэгдэхэд түлхэц болсон.



Хичээлээс гадуурх үйл ажиллагаа  
(гар урлал)



Хичээлээс гадуурх үйл ажиллагаа  
(веб хийх)

## 3. ХАМТЫН ОРОЛЦОО, ДЭМЖЛЭГ

### 3.1. Сургуулийн дэмжлэгийн багийн үйл ажиллагаа (Жишээ 12)



#### Үндсэн мэдээлэл

Аймаг, дүүргийн нэр: Нийслэлийн Хан-Уул дүүрэг  
Сургуулийн нэр: 34 дүгээр дунд сургууль  
Багшийн нэр: Г.Нямбаяр



#### Дэмжлэгийн өмнөх асуудал

Багш нар ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн талаар мэдээлэл дутмаг, тэдэнд хэрхэн зааж сургахаа мэдэхгүй байв.



#### Багшийн дэмжлэгийн арга зүй

Сургуулийн дэмжлэгийн баг нь сургалтын менежер, нийгмийн ажилтан, сургуулийн эмч, сэтгэл зүйч, бага ангийн багш, дунд ангийн багш, эцэг эхийн төлөөлөл, хамран сургах тойргийн сум, багийн удирдлагуудаас бүрддэг. Жил бүр хичээлийн шинэ жил эхэлмэгц дэмжлэгийн багийн хурал зохион байгуулж хичээлийн болон хичээлээс гадуурх үйл ажиллагаа, үнэлгээ, багш нар туршлагаа солилцох, цаашид хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэх хурлыг улирал бүр зохион байгуулдаг.

Сургуулийн дэмжлэгийн баг аль хүүхдэд ямар дэмжлэг үзүүлэхээ дангаар шийдэж хэрэгжүүлдэггүй, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах хүүхдийн эцэг эх, анги удирдсан багшийн хүсэлтийг сонсож, агуулгыг нь хамтдаа ярилцаж шийддэг.



#### Гарсан үр дүн

Тогтмол мэдээлэл, туршлага хуваалцах боломжоор хангаж хэрэгжүүлснээр багш нар нийтлэг нэг ойлголт, мэдээлэлтэй болсон. Мөн дэмжлэгийн багт дунд ангийн багш нар орсон тул дунд ангид элсэн орох хүүхдүүдийг хүлээн авах залгамж холбоо сайжирсан.



Сургуулийн дэмжлэгийн баг

### 3.2. Багш нарын хамтын ажиллагаа (Жишээ 13)



#### Үндсэн мэдээлэл

Аймгийн нэр: Орхон аймаг  
 Сургуулийн нэр: Баян-Өндөр сумын 20 дугаар дунд сургууль  
 Багшийн нэр: Б.Болортуяа



#### Дэмжлэгийн өмнөх асуудал

Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүйгээ мэдэхгүй байсан.



#### Багшийн дэмжлэгийн арга зүй

Бүх багш нар арга зүйн мэдлэгээ сайжруулах, чадавхжих шаталсан сургалтуудад хамрагдсан. Мөн тэгш хамруулан сургах боловсрол үр дүнтэй хэрэгжиж байгаа Хөвсгөл аймгийн Сод-Эрдэм сургуультай танилцаж, тэнд үзсэн, сурсан зүйлээ өөрийн сургуульдаа хэрэгжүүлсэн.



#### Гарсан үр дүн

Тогтмол сургалтад хамрагдсанаар ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд багшлах арга зүйн талаарх ойлголтоо гүнзгийрүүлж, өөрийн сургуульд бодитоор хэрэгжүүлж байна.



Хөвсгөл аймгийн Сод-Эрдэм сургуулийн туршлагаас



Багш нарт зориулсан сургалт

### 3.3. Эцэг эх асран хамгаалагч нартай хамтран ажиллах (Жишээ 14)



#### Үндсэн мэдээлэл

Аймгийн нэр: Сэлэнгэ аймаг  
Сургуулийн нэр: Сүхбаатар сумын 1 дүгээр дунд сургууль  
Багшийн нэр: Б.Дэлгэрцэцэг



#### Дэмжлэгийн өмнөх асуудал

Эцэг эхчүүд хүүхдийнхээ хөгжлийн бэрхшээлийг хүлээн зөвшөөрч байгаа ч хөгжлийн бодит байдлыг ойлгохгүй, багш нараас байнгын зөвлөгөө авч чадахгүй байсан. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ангид орилж хашхирч, бусдын эд зүйлийг зөвшөөрөлгүй шидэх зэрэг асуудалтай зан үйлийг байнга гаргаж байсан.



#### Багшийн дэмжлэгийн арга зүй

Эхлээд сургуулийн дэмжлэгийн багийн гишүүд эцэг эхчүүдтэй ярилцлага хийх ажлыг зохион байгуулав. Үүний дараа эцэг эхчүүдтэй хамтран ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний үндсэн дээр хүүхдийн төлөвшил, бодит байдалд тохируулан нийгэмшихүйн чадварыг сайжруулах үйл ажиллагаа төлөвлөн, хүүхдийн онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж, эцэг эхчүүдтэй хэд хэдэн удаагийн ярилцлага хийснээр эцэг эхчүүд хүүхдийнхээ хөгжлийн байдлыг зөв ойлгож, хүүхдийнхээ хөгжлийн үе шатанд тохирсон сургалтын арга зүйн талаар багш нараас зөвлөгөө авдаг, асуудаг болсон.



#### Гарсан үр дүн

Сургуулийн орчинд, гэрийн нөхцөлд хүүхдийн хөгжилд тохирсон үйл ажиллагаа, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтыг багш, эцэг эхчүүд ярилцан хамтран ажиллах боломжтой боллоо. Ангид хүүхдийн хашхирах нь багсаж, унших, бичих, нэмж хасах үйлдэл хийх гэх мэт үндсэн ойлголтууд сайжирсан.



Эцэг эхчүүдэд зориулсан үйл ажиллагаа



Хүүхдийн гэртээ хичээллэж буй байдал

### 3.3. Эцэг эх асран хамгаалагч нартай хамтран ажиллах (Жишээ 15)



#### Үндсэн мэдээлэл

Аймгийн нэр: Орхон аймаг  
 Сургуулийн нэр: Баян-Өндөр сумын 18 дугаар дунд сургууль  
 Багшийн нэр: Ц.Ганзул



#### Дэмжлэгийн өмнөх асуудал

Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн талаар багш нарын дунд нэгдсэн ойлголтгүй байсан. Сургуулийн хамран сургах тойргийн сургуульд хамрагдаагүй хүүхдүүд байдаг байсан.



#### Багшийн дэмжлэгийн арга зүй

Сургуулийн багш нараас бүрдсэн мэргэжлийн хөгжлийн бүлгийг байгуулж, хамран сургах тойргийн сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн гэрт нь очиж уулзсан. Хүүхдүүд болон тэдний эцэг эхчүүдтэй хүүхдийн онцлогийн талаар болон сургуульд элсүүлэхэд хэрэгтэй анхаарах асуудлын талаар ярилцаж, зөвлөгөө өгсөн.



#### Гарсан үр дүн

Одоогийн байдлаар сургууль завсардсан есөн хүүхдийн хоёр нь сургуульд элсэх боломжтой болсон.



Гэрээр нь очих үед



Мэргэжлийн хөгжлийн бүлгийн ярилцлагын үеэр

### 3.4. Хүүхэд хоорондын харилцаа (Жишээ 16)

#### Үндсэн мэдээлэл

Аймгийн нэр: Булган аймаг  
Сургуулийн нэр: Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль  
Багшийн нэр: Б.Үүрийнцолмон

#### Дэмжлэгийн өмнөх асуудал

Ангийн хамгийн ард суугаад хашхирч бусад хүүхдүүдийн анхаарлыг татдаг. Ангийн хүүхдүүдийг өөрт нь таагүй зүйл гарах л юм бол цохидог, түрэмгий зантай.

#### Багшийн дэмжлэгийн арга зүй

Хамгийн урд эгнээнд суулгаж, багш ойр ойрхон харилцдаг байхад анхаарсан. Мөн ялгаатай хэрэгцээтэй хүүхэд хүүхэд төдийгүй ангийн бусад хүүхдүүдтэй хэрхэн харилцах талаар зааж сургаснаар ангид эерэг уур амьсгал бүрдэж чадсан. Тухайлбал тухайн хүүхдийг хичээлээ тасалсны маргааш нь хүүхдүүд “Өдөр бүр, сургууль ангидаа уулзана гэж боддог”, “Хичээлээ битгий таслаарай” гэх мэтээр хэлж, хүүхдүүдийг хооронд нь яриулдаг болсон.

#### Гарсан үр дүн

Сургуульд ирэхдээ дургүй байсан хүүхэд ангийн хүүхдүүдтэй найзалснаас хойш ирэх дуртай болсон. Хүүхэд цохихоо больсон. Зөвхөн зорилтот хүүхэд төдийгүй анги нийтээрээ бусдыгаа хүндэтгэх уур амьсгал бий болсон.



Хичээлийн явцад



Ангийн орчин



9789919905590